



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 14 өдөр

Дугаар А/325

Эрдэнэт

Үзлэг зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/a/, 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.2, 11.1.8, Монгол улсын Засгийн газрын 2017 оны 24 дүгээр “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого” тогтоолын 2.4.1.8, Монгол улсын Засгийн газрын 2017 оны 78 дугаар тогтоол “Эх хүүхэд нөхөн үржихүйн хөтөлбөр”, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн ээлжит III хуралдааны 01 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн VI хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орхон аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө"-ний 1.1.9.8, аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн 1.1.9.8 дахь заалт, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн Засаг даргатай байгуулсан гурвалсан гэрээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нөхөн үржихүйн насны өртөмтгий бүлгийн эмэгтэйчүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын удирдамжийг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2.Шаардагдах зардал 5000000 /Таван сая/ төгрөгийг “Нөхөн үржихүйн насны өртөмтгий бүлгийн эмэгтэйчүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулах зардал”-аас гаргахыг Санхүү төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

3.Батлагдсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулан, үр дүнг тайлагнаж ажиллахыг Эрүүл мэндийн газар/н.Баттүвшин/-т, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /н.Буман сор/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.БАТЛУТ



Аймгийн Засаг даргын 2017 оны
06 дугаар сарын 14-ны өдрийн
1/325 дугаар захирамжийн хоёрдугаар
хавсралт

**НӨХӨН ҮРЖИХҮЙН НАСНЫ ӨРТӨМТГИЙ БҮЛГИЙН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГТ ХАМРУУЛАН ЭМЧЛЭН ЭРҮҮЛЖҮҮЛЭХ
АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ТӨСӨВ**

№	Үзлэгт шаардагдах зүйлс	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төг/	Нийт үнэ
1	Жирэмсний тест	Ширхэг	500	500	250000
2	1 удаагийн аяга	Ширхэг	500	50	25000
3	Бээлий	Хайрцаг	14	8500	119000
4	1 удаагийн дэвсгэр	Ширхэг	1465	1000	146500
5	1 удаагийн толь	Ширхэг	1465	1200	1758000
6	ЭХО оношлогоо	Хүн	200	5000	1000000
7	Наацын шил, савх	Ширхэг	500	1500	750000
8	Доксициклин 0.25 №10	Ширхэг	301	1500	451500
9	Метронидазол 0.5 №10	Ширхэг	250	2000	500000
	Бүгд				5000000